



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/133

Арвайхээр сум

Цасны нэмэлт хэмжилт хийж,
зудын эрсдлийн үнэлгээ хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол улсын Засгийн газрын 286 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Ган зудын байдалд үнэлгээ хийх заавар"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны 11 дүгээр сараас эхлэн нийт сумдын нутгаар цаг агаарын нөхцөл байдал, өвөлжилт хүндэрч зарим нутгаар зудын эрсдэл үүсэж байгаатай холбогдон өвлийн бэлчээрийн цасны нэмэлт ажиглалтыг бүх сумдын нутаг дэвсгэрийг хамруулан хийж мэргэжлийн баг гарган зудын эрсдэлийн үнэлгээ гаргах ажлыг зохион байгуулж тухай бүр нь мэдээлж байхыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Ч.Чанцалдиймаа)-д даалгасугай.

2.Цаг үеийн нөхцөл байдал хүндэрсэн үеийн судалгаанд шаардагдах шатахуун болон бусад зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Хавсралтанд тусгагдсан 13,100,000 (арван гурван сая нэг зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0302

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар
сарын 28 -ны өдрийн 153 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРЬ

№	Нэр төрөл	Төсөв өртөг (мянган төгрөг)
1.	Нийт сумдын нутгаар цасны хээрийн хэмжилт хийхэд шаардлагатай шатахууны зардал (13200км)	8,812,500
2.	Нийт сумдын нутгаар цасны хээрийн хэмжилт хийхэд шаардлагатай албан томилолтын зардал (13200км)	2,880,000
3.	Багц мессежний бүх төрлийн үйлчилгээ (Үүрэн телефоны зардал, модемь, гар утас, интернет)	1,407,500
	Нийт зардал	13,100,000

-оОо-